



BUYANT-UKHAA
INTERNATIONAL AIRPORT

“БУЯНТ-УХАА” ОЛОН УЛСЫН НИСЭХ БУУДЛЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 03 сарын 21 өдөр

Дугаар А/26

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.6 дахь заалт, Иргэний нисэхийн ерөнхий газрын Хөдөлмөрийн дотоод журмын 3.26.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудлын “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар баримтлах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Журмыг батлагдсан өдрөөс эхлэн дагаж, мөрдөж ажиллахыг нэгжийн дарга нарт үүрэг болгосугай.

3. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дэд дарга (Б.Ганбаатар)-д даалгасугай.

ДАРГА



Л.ОТГОНЖАРГАЛ

000124



ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ТАЛААР БАРИМТЛАХ ЖУРАМ

БУОУНБ-ҮЖ-001:2022

1 дэх хэвлэл

**Улаанбаатар хот
2022 он**

БАТАЛГААЖУУЛАЛТЫН ХУУДАС

Энэхүү хуудас нь “Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудлын “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар баримтлах журам”-ын хамт хүчин төгөлдөр байна.

БАЙГУУЛЛАГА: “БУЯНТ-УХАА” ОЛОН УЛСЫН НИСЭХ БУУДАЛ

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ТАЛААР
БАРИМТЛАХ ЖУРАМ

Боловсруулсан:	Хянасан:	Баталсан:
Албан тушаал: Дотоод хяналт, аюулгүй ажиллагааны хэлтсийн хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн Нэр: Э.Энхжаргал Гарын үсэг:  Огноо: 2022.03.21.	Албан тушаал: Дотоод хяналт, аюулгүй ажиллагааны хэлтсийн дарга Нэр: Б.Алтантуяа Гарын үсэг:  Огноо: 2022.03.21.	Албан тушаал: “Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудлын дарга Нэр: Л.Отгонжаргал Гарын үсэг:  Огноо: 2022-03-21.

БАРИМТ БИЧГИЙН ХЯНАЛТЫН МЭДЭЭЛЭЛ

Баримт бичгийн дэлгэрэнгүй <i>Document Details</i>					
1.	Баримт бичгийн нэр <i>Document Name</i>	“Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудлын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар баримтлах журам			
2.	Баримт бичгийн зорилго <i>Purpose of the Document</i>	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх “Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудлын бодлого, зарчмыг тодорхойлж, хяналтын тогтолцоо, ажлын байранд тавигдах хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандартыг хангах, ажилтныг эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр хийх ажлын уялдаа холбоог хангахтай холбогдсон харилцааг зохицуулна.			
3.	Баримт бичгийн код <i>Unit Identification</i>	БОУНБ-ҮЖ-001:2022			
4.	Хуудасны тоо <i>Total page</i>	18 хуудастай			
5.	Хэлбэр <i>Document Status</i>	Хэвлэмэл А-4			
6.	Хариуцах албан тушаалтан <i>Document Owner</i>	Дотоод хяналт, аюулгүй ажиллагааны хэлтсийн Хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн			
7.	Батлагдсан огноо <i>Date approved</i>	2022.03.21			
8.	Баталсан байгууллага, албан тушаалтан <i>Approved by</i>	“Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудлын дарга			
9.	Өөрчлөлт, нэмэлт орсон байдал <i>Amendments</i>	-			
10.	Баримт бичгийн бүтэц <i>Document Structure</i>	13 Бүлэг			
11.	Хавсралт <i>Appendix</i>	-			
12.	Тарагдсан байдал <i>Distribution</i>	Хэлтэс, алба <i>Division name</i>	Хяналтын дугаар	Хувь <i>Version</i>	Гарын үсэг <i>Signature</i>
		ЗСТХ	01	1	
		ДХААХ	02	1	
		ҮТЗХХ	03	1	
		АХ	04	1	
		АГУХ	05	1	
		ГСХСХ	06	1	
		ТҮХ	07	1	
		Нийт Total		7	

“Буянт-Ухаа” ОУНБ-ын “Баримт бичгийн хяналтын журам”-д заасны дагуу нэмэлт, өөрчлөлтийг уг журмыг Хянасан албан тушаалтан хянан баталгаажуулна. Шаардлагатай бол журмыг баталгаажуулсан албан тушаалтанд танилцуулж, зөвшөөрөл авсан байна.

Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах ажилтан доорх хүснэгтийг заавал бөглөсөн байх шаардлагатай. Нэмэлт, өөрчлөлтийн талаарх агуулгын дэлгэрэнгүй мэдээллийг “Бүртгэлийн хяналтын журам”-д заасны дагуу бүртгэнэ.

НЭМЭЛТ БОЛОН ӨӨРЧЛӨЛТИЙН БҮРТГЭЛ

НЭМЭЛТ БОЛОН ӨӨРЧЛӨЛТҮҮД					
Дугаар	Хүчинтэй болох огноо	Оруулсан огноо	Нэмэлт өөрчлөлтийн зүйл, заалтын дугаар	Тэмдэглэгээ /-/ /+/	Гарын үсэг


ГАРЧИГ

Бүлэг	Агуулга	Хуудас
	Баталгаажуулсан хуудас	1
	Баримт бичгийн хяналтын мэдээлэл	2
	Нэмэлт болон өөрчлөлтийн бүртгэл	3
	Гарчиг	4-5
1-Р БҮЛЭГ	Нийтлэг үндэслэл	6
2-Р БҮЛЭГ	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар баримтлах бодлого	6
2.1.	Аюулгүй ажиллагааны бодлого	6
2.2.	Эрүүл мэндийн бодлого	6
3-Р БҮЛЭГ	“Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудлын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үйл ажиллагаандаа баримтлах зарчим	7
4-Р БҮЛЭГ	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандарт	7
4.1.	Үйлдвэрлэлийн орчин, барилга байгууламж	7
4.2.	Машин механизм, тоног төхөөрөмж	7
4.3.	Өргөх, зөөх, тээвэрлэх механизм	8
4.4.	Даралтат сав, шугам хоолой	8
4.5.	Химийн хорт ба аюултай бодис, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, цацраг, биологийн идэвхит бодистой харьцах	8
4.6.	Галын аюулгүй байдал	8
4.7.	Эрүүл мэндийн үзлэг	9
4.8.	Ажилтныг ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр хангах	9
4.9.	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон мэргэжлийн сургалт	9
5-Р БҮЛЭГ	Тав. “Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудлын ажилтнуудын хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулахтай холбогдсон эрх, үүрэг	10
5.1.	Ажилтнуудын эрх	10
5.2.	Ажилтнуудын үүрэг	10
6-Р БҮЛЭГ	Зургаа. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зохион байгуулалт, албан тушаалтнуудын чиг үүрэг	11
6.1.	Зохион байгуулалт	11
6.2.	Албан тушаалтнуудын чиг үүрэг	11-12
7-Р БҮЛЭГ	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар байгууллагын эрх, үүрэг	13
7.1.	“Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудлын хүлээх үүрэг	13
7.2.	“Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудлын эдлэх эрх	14
8-Р БҮЛЭГ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц хордлого, тэдгээрийг судалж бүртгэх	14
8.1.	Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын үед байгууллагын зүгээс авах арга хэмжээ	14

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ТАЛААР БАРИМТЛАХ ЖУРАМ - БУОУНБ-ҮЖ-001:2022

8.2.	Мэргэжлээс шалтгаалах өвчин	14
9-Р БҮЛЭГ	Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ	14
10-Р БҮЛЭГ	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналт	15
11-Р БҮЛЭГ	Манлайлал	15
12-Р БҮЛЭГ	Идэвхжүүлэлт	15
13-Р БҮЛЭГ	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн арга хэмжээний санхүүжилт	16
	Хоосон үлдээв	17
	Нэмэлт, өөрчлөлтийн талаарх мэдээлэл	18

“Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудлын
даргын 2022 оны 03 дугаар сарын 21 ний
өдрийн 1/26 дугаар тушаалын хавсралт



“БУЯНТ-УХАА” ОЛОН УЛСЫН НИСЭХ БУУДЛЫН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ТАЛААР БАРИМТЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журам нь Монгол улсын Үндсэн хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад акт, стандарт, дүрэм журмыг үндэслэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх “Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудлын бодлого, зарчмыг тодорхойлж, хяналтын тогтолцоо, ажлын байранд тавигдах хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандартыг хангах, ажилтныг эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр хийх ажлын уялдаа холбоог хангахтай холбогдсон харилцааг зохицуулна.

Хоёр. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар баримтлах бодлого

2.1. Аюулгүй ажиллагааны бодлого

2.2.1. Ажилтнуудыг хөдөлмөрлөх явцад гарч болзошгүй үйлдвэрлэлийн осол бэртэл, өвчлөлөөс хамгаалах, эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн зохион байгуулалтыг хийж үйл ажиллагаандаа аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан техник, тоног төхөөрөмжийг нэвтрүүлж, нийт ажилтны ажлын байран дахь аюулгүй байдлыг хангана.

2.2. Эрүүл мэндийн бодлого

2.3.1. Байгууллагын хэмжээнд ажлын байранд ажлын болон ажлын бус цагаар архи, согтууруулах ундаа, тамхи хэрэглэхгүй байх талаар сурталчлах, мэдээлэх, амьдралын зөв хэвшлийг бий болгох ажлыг системтэйгээр зохион байгуулах, ажлын ачааллаас шалтгаалан ядрах эрсдэлийг тодорхойлох, ажил, амралтын цагийг зөв зохицуулдаг хэвшил бий болгоход чиглэж ажиллана

Гурав. “Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудлын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үйл ажиллагаандаа баримтлах зарчим

- 3.1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандартыг хэрэгжүүлэх байнгын хяналтын тогтолцоог бүрдүүлнэ.
- 3.2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаархи мэдээллийн ил тод, үнэн бодит байдлыг хангана.
- 3.3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн хөдөлмөрийн хэвийн нөхцлийг бүрдүүлнэ.

Дөрөв. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандарт

4.1. Үйлдвэрлэлийн орчин, барилга байгууламж

4.1.1. Үйлдвэрлэлийн барилгыг өргөтгөх, шинэчлэх, машин техник, тоног төхөөрөмж угсрах, суурилуулах, туршилт, засвар хийх үйлчилгээ нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн байна.

4.1.2. Үйлдвэрлэлийн барилга байгууламжийг гэрээгээр эзэмшигч, ашиглагч нь:

- үйлдвэрлэлийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт, шаардлагыг хангаж ажиллана.
- үйлдвэрлэлийн явцад химийн хорт ба аюултай бодис, тэсэрч дэлбэрэх бодис, цацраг, биологийн идэвхит бодисыг хэрэглэж буй бол энэ тухай харилцан бие биедээ мэдээлж, аюулгүй байдлыг хангах нэгдсэн арга хэмжээ авах бөгөөд мэдээлээгүйн улмаас учирсан хохирлыг буруутай тал нь бүрэн хариуцна.

4.2. Машин механизм, тоног төхөөрөмж

4.2.1. Үйлдвэрлэлийн зориулалттай, хүний эрүүл мэндэд аюул учруулж болох машин механизм, тоног төхөөрөмжийн бүтэц, хийц, хөдөлгөөнт хэсэг, удирдлага, дохиоллын систем, бүрдэл хэсэг (ажлын байр, гарц, шат, хашлага, хамгаалах хэрэгсэл) нь аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан байх ба машин механизм, тоног төхөөрөмжийг ажиллуулах, засвар үйлчилгээ хийх үед мөрдөх ашиглалт, аюулгүй ажиллагааны заавар, техникийн паспорттай байна.

4.2.2. Машин механизм, тоног төхөөрөмжийг суурилуулах, их засварын дараа ашиглалтад оруулахдаа техникийн комиссоор хянуулж, дүгнэлт гаргуулах ба шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулж болно.

4.2.3. Машин механизм тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээ, тохируулгыг техникийн баримт бичигт заасан хугацаанд тогтмол хийж байна.

4.2.4. Машин механизм, тоног төхөөрөмжийг бусдад шилжүүлэхдээ ашиглалтын паспорт, гэрчилгээний хамт шилжүүлнэ.

4.2.5. Цахилгаан байгууламж, тоног төхөөрөмж нь хаалт, хашилттай, хаалга нь цоожтой, хориглох тэмдэгтэй байх ба туршигдсан хамгаалах хэрэгслээр хангагдсан байна.

4.2.6. Цахилгаан байгууламж, тоног төхөөрөмж нь зураг төслийн дагуу угсрагдсан, аюулгүй ажиллагааны нөхцлийг хангахаар бүрэн бүтэн, газардуулгын байгууламжид холбогдсон байна. Цахилгаан байгууламж тоног төхөөрөмжийн газардуулгын холболтын бүрэн бүтэн байдлыг тогтмол шалгаж, эсэргүүцлийн хэмжилтийг баталгаажсан лабораториор техник ашиглалтын дүрмийн шаардлагын дагуу гүйцэтгүүлнэ.

4.3. Өргөх, зөөх, тээвэрлэх механизм

4.3.1. Өргөх, зөөх, тээвэрлэх хэрэгслийн техникийн бүрэн бүтэн байдлыг хангасан байх ба мэргэжлийн байгууллагаар техникийн магадлагаа хийлгэж, зохих зөвшөөрлийг авсан байна.

4.3.2. Өргөх, зөөх, тээвэрлэх хэрэгсэлд засвар, үйлчилгээ, тохируулгыг техникийн баримт бичигт заасан болон эрх бүхий байгууллагын баталсан хугацаанд туршилт, тохируулга, баталгаажуулалтыг хийлгэсэн байна.

4.4. Даралтат сав, шугам хоолой

4.4.1. Даралтат сав, шугам хоолойн зохих журмын дагуу техникийн бүрэн бүтэн байдлыг хангаж, ашиглах зөвшөөрөл авсан байх бөгөөд холбогдох баримт бичгийн дагуу аюулгүй ажиллагааг хангасан байна.

4.4.2. Даралтат сав, шугам хоолойг зориулалтын ялгагдах таних тэмдэг, ослоос урьдчилан сэргийлэх хянах хэрэгслээр тоноглогсон байна.

4.5. Химийн хорт ба аюултай бодис, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, цацраг, биологийн идэвхит бодистой харьцах

4.5.1. Химийн хорт ба аюултай бодис, тэсэрч дэлбэрэх бодис, цацраг, биологийн идэвхит бодисыг үйлдвэрлэлийн явцад хэрэглэж буй албад энэ талаар тэмдэглэл хөтлөн, эрх бүхий байгууллагаас баталсан журмын дагуу хөдөлмөрийн хяналтын болон холбогдох мэргэжлийн байгууллагад мэдээлж түүний нөлөөллөөс ажилтны амь нас, эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.

4.5.2. Химийн хорт ба аюултай бодис, тэсэрч дэлбэрэх бодис, цацраг, биологийн идэвхт бодистой харьцах ажилтан нь тухайн бодисын эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөлөл, түүнээс урьдчилан сэргийлэх талаар зохих мэдлэг, дадлагатай байна.

4.6. Галын аюулгүй байдал

4.6.1. Галын аюулаас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, энэ талаарх үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, байнгын хяналт тавих үүрэгтэй “Галын аюулгүй байдлыг хангах бүлэг”-ийг байгууллагын даргын тушаалаар байгуулж ажиллуулна.

4.6.2. Нэгжүүд нь өөрсдийн ажлын байранд галын аюулаас урьдчилан сэргийлэх болон гал унтраах дүрэм, журам, стандартыг хангаж ажиллах үүрэг хүлээнэ.

4.6.3. Галын дохиолол болон гал унтраах тусгай тоноглол, гарц, орцын зураглалыг гал гарч болзошгүй ажлын байр бүрт байрлуулан, тэдгээрийг тогтмол ажиллагаатай байлгаж, ажилтныг уг тоноглолыг ашиглаж сургасан байна.

4.7. Эрүүл мэндийн үзлэг

4.7.1. Эрүүл мэндийн хугацаат үзлэгт хамруулах ажил мэргэжлийн жагсаалтыг Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын тушаалаар батлуулан холбогдох ажилтнуудыг эрүүл мэндийн хугацаат үзлэгт хамруулна.

4.7.2. Хугацаат үзлэгт хамрагдаагүй ажилтнуудыг эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт 2 жилд нэг удаа хамруулна.

4.7.3. Эрүүл мэндийн хугацаат болон урьдчилсан үзлэгт зарцуулах зардлыг байгууллага жил бүрийн төсөвтөө тусгана.

4.7.4. “Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудалд шинээр ажилд орж буй иргэд эмнэлгийн үзлэгт заавал хамрагдсан байна.

4.8. Ажилтныг ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр хангах

4.8.1. Байгууллагаас ажилтныг түүний ажлын нөхцөл, ажил үүргийн онцлогт тохирсон ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр үнэ төлбөргүй хангах ба тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг турших, худалдаж авах, хадгалах, угааж цэвэрлэх, засварлах, ариутгах зардлыг байгууллага хариуцна.

4.8.2. Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийн нэр, төрөл, эдэлгээний хугацаа бүхий жагсаалтыг удирдах газраас баталж мөрдүүлнэ.

4.8.3. Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийн чанарын талаар мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулна. Олон улсын стандартын дагуу үйлдвэрлэсэн, чанарын баталгаа бүхий ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэлд дүгнэлт гаргах шаардлагагүй.

4.9. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон мэргэжлийн сургалт

4.9.1. Сургалтыг дараах төрлөөр зохион байгуулна. Үүнд:

- шинээр ажилд орж байгаа иргэний сургалт;
- өөр ажлын байранд шилжиж байгаа ажилтны сургалт;
- үйлдвэрлэлийн хортой, аюултай хүчин зүйлийн үйлчлэл бүхий болон тэдгээртэй адилтгах эрсдэлтэй ажлын байранд ажиллаж байгаа иргэн, ажилтны сургалт;

4.9.2. Шинээр ажилд орж байгаа иргэнд тусгайлан боловсруулсан хөтөлбөрийн дагуу Хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан ажилтан сургалт явуулна. Сургалтыг зааварчилгаа хэлбэрээр явуулж болно.

4.9.3. Үйлдвэрлэлийн хортой, аюултай хүчин зүйлийн үйлчлэл бүхий өргөх, тээвэрлэх механизм, даралтат сав, шугам хоолой, цахилгаан тоног төхөөрөмж, химийн хортой, тэсрэх болон цацраг, биологийн идэвхт бодис хэрэглэж байгаа зэрэг онцгой нөхцөлд ажиллах ажилтныг мэргэжлийн болон хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн тусгай хөтөлбөр бүхий сургалтад ажил олгогч хамруулна.

Тав. “Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудлын ажилтнуудын хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулахтай холбогдсон эрх, үүрэг

5.1. Ажилтнуудын эрх:

- 5.1.1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангасан ажлын байранд ажиллах;
- 5.1.2. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд хамрагдах;
- 5.1.3. Ажлын байрны нөхцөл, эрүүл мэндэд учирч болох эрсдэл, түүнчлэн үйлдвэрлэлийн аюултай, хортой хүчин зүйлийн талаар бодит мэдээлэл авах;
- 5.1.4. Ажил, үүргээ биелүүлэх явцад хөдөлмөрийн аюулгүй байдлын журам зөрчигдсөн болон амь нас, эрүүл мэндэд нь сөрөг, аюултай нөхцөл бий болсон тохиолдолд ажлаа зогсоож, энэ талаар ажил олгогчид мэдэгдэх;
- 5.1.5. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хэлэлцэхэд өөрөө болон төлөөлөгчөөрөө дамжуулан оролцох;

5.2. Ажилтнуудын үүрэг:

- 5.2.1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандарт, дүрэм, технологийн горимыг чанд мөрдөх;
- 5.2.2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдсан байх, хуульд тусгайлан заасан бол шалгалт өгсөн, аюулгүй ажиллагааны зааварчилга авсан байх;
- 5.2.3. Хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцад амь нас, эрүүл мэндэд сөрөг нөлөөлөх нөхцөл бий болсон тохиолдолд аюулгүй байдлын дүрэм, журамд заасны дагуу шуурхай арга хэмжээ авах;
- 5.2.4. Эрүүл мэндээ хамгаалах, эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд орох;
- 5.2.5. Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг зориулалтын дагуу хэрэглэх;
- 5.2.6. Ажил, үүргээ осол эндэгдэлгүй гүйцэтгэх арга барил, мэргэжлийн ур чадвар эзэмших, осол гэмтэл, хурц хордлогоос сэргийлэх, болзошгүй аюул, ослын үед анхны тусламж үзүүлэх чадвар эзэмшсэн байх;
- 5.2.7. Өөрийгөө болон бусдыг аюул, эрсдэлд учруулахгүй байх;
- 5.2.8. Байгууллагын зүгээс хууль тогтоомжийн хүрээнд нийцүүлэн тавьсан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг биелүүлж ажиллах;

Зургаа. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зохион байгуулалт, албан тушаалтнуудын чиг үүрэг

6.1. Зохион байгуулалт

- 6.1.1. Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хяналт тавих үүргийг “Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудлын дарга хариуцна.
- 6.1.2. “Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудал нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан орон тооны ажилтан, даргын тушаалаар байгуулсан орон тооны бус дэд зөвлөлтэй байна. Дэд зөвлөлийг орон тооны ажилтан ахалж ажиллана.
- 6.1.3. Үйлдвэрлэл, үйлчилгээний онцлог, ажлын байрны эрсдэлийн түвшин, ажилтны тоог харгалзан Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан бүтэц/нэгж/-ийг байгуулж болно.

6.1.4. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан дэд зөвлөл нь ажиллах журамтай байх бөгөөд журмын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж, жил бүр удирдлага, хамт олонд ажлаа тайлагнана.

6.1.4. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан дэд зөвлөл болон ажилтны ажлын чиг үүрэгтэй холбогдуулан тавьсан шаардлагыг байгууллагын бусад ажилтан, албан тушаалтан биелүүлэх үүрэгтэй.

6.2. Албан тушаалтнуудын чиг үүрэг

6.2.1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан дэд зөвлөл болон ажилтан:

6.2.1.1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн бодлого, төлөвлөгөөг боловсруулж, шаардлагатай дүрэм, журмыг шинэчлэн баталж хэрэгжүүлэх;

6.2.1.2. Үйлдвэрлэлийн осол эндэгдлээс урьдчилан сэргийлэхэд тэргүүлэх ач холбогдол бүхий хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх, хэрэгжилт үр дүнд хяналт тавих;

6.2.1.3. Удирдах болон нийт ажилтнуудыг хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн мэргэжлийн зохицуулалт, арга зүйгээр хангаж, аюулгүй, эрүүл орчинд ажиллах соёл, дадалд уриалах;

6.2.1.4. Хууль тогтоомжийн хэрэгжилтэнд үзлэг шалгалт хийж, хяналт тавих илэрсэн зөрчлийг арилгуулах;

6.2.1.5. Байгууллагын хэмжээнд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчлөл гаргуулахгүй байх;

6.2.1.6. Ажилтнуудын ажлын байрны эрүүл ахуйн орчныг сайжруулах, нөхцөл бололцоог хангах үйл ажиллагааг системтэйгээр явуулах;

6.2.1.7. Галын аюулгүй байдлыг хангах, урьдчилан сэргийлэх;

6.2.1.8. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар сургалт зохион байгуулах

6.2.1.9. Ажлын нөхцөл, мэргэжлийн онцлогт тохирсон тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг ажилтанд олгуулах, норм, чанар, зохистой хэрэглээнд хяналт тавих;

6.2.1.10. Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийн хангалт, хэрэглээ, ахуйн байр, ариун цэвэр эрүүл ахуйн болон эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан байдал, түүний мөрөөр хийгдсэн эмчилгээ, сувилгаатай танилцах;

6.2.1.11. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар ажилтны гаргасан санал хүсэлтийг шийдвэрлэх талаар захиргаанд зөвлөмж, шаардлага өгөх;

6.2.3. БУОУНБ-ын дарга

- Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хяналт тавих үүргийг нисэх буудлын дарга шууд хариуцна.

- Нисэх буудлын ажилтнуудыг тусгай сургалтад хамруулах;

- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан ажилтнаа томилгоожуулж, ажлын байрны тодорхойлолтод зохих чиг үүргийг тусгуулах;

- Үйл ажиллагааны онцлогтоо тохируулан “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар баримтлах журам” боловсруулан мөрдүүлэх;

- Байгууллагын хэмжээнд галын аюулгүй байдлыг хангах сайн дурын бүлгэм ажиллуулах

- Галын сургуулилт жил бүр хийлгэх;
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар мэдлэг олгох сургалт зохион байгуулж, мэдлэгийг шалгах;
- Үйлдвэрлэлийн үйл ажиллагаандаа ашиглаж буй тоног төхөөрөмж, машин механизмыг засварлах, шинээр суурилуулах бүртээ зохих албан тушаалтанд мэдэгдэх;

Хууль, тогтоомжид заасан бусад чиг үүрэг:

6.2.4. Нэгжийн дарга, инженер техникийн ажилтан:

- а. Хөдөлмөр хамгааллын ажлыг хариуцсан нэгж, хэсэг дээрээ баг эсхүл хариуцах ажилтнуудыг томилох замаар зохион байгуулах,
- б. Аюулгүй ажиллагааны зааварчилга өгөх, сургалтад хамрагдаагүй, зааварчилга аваагүй, шалгалт өгөөгүй ажилтнаар ажил үүрэг гүйцэтгүүлэхгүй байх;
- в. Аюулгүй ажиллагааны заавар боловсруулах, ажилтнуудаа сургаж, анхан шатны болон давтан зааварчилгаа өгөх, хяналт тавих;
- г. Гарсан осол мэргэжлээс шалтгаалах өвчлөлд дүн шинжилгээ хийж хойшид үүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллах;
- д. Хууль, тогтоомжид заасан бусад чиг үүрэг;

7.1.16. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөлийг хангах арга хэмжээ, түүнд шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөв, төлөвлөгөө, хамтын гэрээнд тусгаж, зориулалтаар нь зарцуулах;

7.1.17. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц хордлогын улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан ажилтанд хууль тогтоомжийн дагуу нөхөн төлбөр олгох;

7.1.18. Ажиллагсдын аюулгүй, эрүүл ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;

7.2. “Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудлын эдлэх эрх:

7.2.1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан дэд зөвлөл байгуулах, ажилтныг ажилд томилох, ажлаас чөлөөлөх;

7.2.2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ, түүний төсөв, зардлыг баталж, хэрэгжүүлэх;

7.2.3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм, журмыг зөрчсөн ажилтанд Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, байгууллагын дотоод журамд заасан хариуцлага хүлээлгэх;

7.2.4. Ажилтан ажилдаа ирж, буцах маршрутаа гарган гарын үсгээр баталгаажуулж, захиргаа хариуцсан нэгжид өгөх ба өөрчлөгдөх тохиолдолд тус нэгжид мэдэгдэж, өөрчлөлт хийлгэн баталгаажуулах үүрэгтэй. Баталгаажуулалт хийлгээгүй, баталгаажуулснаас өөр маршрутаар явсан, эсхүл ажлын байрнаас гэр хүртэл зарцуулах хугацаанаас хэтэрсэн үед гарсан ослын хариуцлагыг ажил олгогч хүлээхгүй.

Найм. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц хордлого, тэдгээрийг судалж бүртгэх

8.1. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын үед байгууллагын зүгээс авах арга хэмжээ

8.1.1. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн иргэн, ажилтныг өөрийн зардлаар эмнэлэгт хүргэх, шаардлагатай үзлэг шинжилгээний зардлыг хариуцах, үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын хор уршгийг арилгах арга хэмжээг 24 цагийн дотор авна;

8.1.2. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарах бүрт Засгийн газраас тогтоосон журмын дагуу осол, хурц хордлогыг тогтоох, судлан бүртгэх үүрэгтэй бөгөөд үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын шалтгааныг тогтоох акт, дүгнэлт гаргах үүрэг бүхий ИНҮТ-ийн даргын тушаалаар байгуулагдсан орон тооны бус байнгын комисс ажиллана;

8.1.3. Үйлдвэрлэлийн ослын актыг хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч, хурц хордлогын дүгнэлтийг хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч нараар тус тус хянуулна.

8.1.4. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн ажилтан дүгнэлтийг зөвшөөрөхгүй бол гомдлоо хөдөлмөрийн мэргэжлийн хяналтын байгууллага болон шүүхэд гаргаж болно.

8.1.5. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судалж бүртгэх зардлыг байгууллага хариуцна.

8.1.6. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц хордлогын тухай мэдээг тогтоосон журмын дагуу дүүргийн статистикийн байгууллагад мэдээлнэ.

8.2. Мэргэжлээс шалтгаалах өвчин

8.2.1. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас бий болсон хөдөлмөрийн чадвар алдалт, түүний хувь хэмжээ, хугацааг Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссоор шийдвэрлүүлнэ.

Ес. Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ

9.1. Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэнэ.

9.2. Ажлын байр шинээр бий болгох болон тухайн ажлын байрны үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэл, нөхцөл өөрчлөгдөх бүрт нь, химийн хорт болон аюултай бодис агуулсан түүхий эд, материал ашиглан үйл ажиллагаа явуулах бол жилд нэгээс доошгүй удаа ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг тус тус хийлгэнэ.

Арав. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналт

10.1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дэд зөвлөл нисэх буудлын хэмжээнд сар тутам, нэгжийн дарга болон тухайн нэгжид хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцахаар томилгоожсон ажилтнууд өдөр тутам, ажлын байр бүрт хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомж, нийтлэг шаардлага, стандартын хэрэгжилт, ажлын байран дахь эрсдэлийн үнэлгээний дагуу авагдсан арга хэмжээний биелэлтэд дотоодын хяналт тавина.

10.2. Дотоод хяналтын нэгжийн үзлэг, шалгалтын явцад илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээг тухайн нэгжийн дарга зохион байгуулж, үр дүнг хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн асуудал хариуцсан дэд зөвлөл, орон тооны ажилтанд мэдэгдэнэ.

10.3. Ажилтны төлөөлөгч болон ажилтан нь байгууллагын дотоод хяналт тавих үйл ажиллагаанд оролцох эрхтэй.

Арван нэг. Манлайлал

11.1. “Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудлын захиргаа, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн асуудал хариуцсан дэд зөвлөл, орон тооны ажилтан, нэгжийн удирдлагууд аюулгүй ажиллагааны чиглэлд манлайлагч байж, байгууллагын хэмжээнд аюулгүй ажиллагааны стандарт, журам, зааврын хэрэгжилтийг оновчтой, тогтвортой зохион байгуулж хэвшүүлэхэд гол үүргийг гүйцэтгэнэ.

Арван хоёр. Идэвхжүүлэлт

12.1. Ажлын байрны нөхцөл сайжруулах, үйлдвэрлэлийн осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангах чиглэлээр “Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудлын даргын нэрэмжит болзолт уралдаан зарлаж, үлгэр жишээ ажлын байр, осол зөрчилгүй ажилласан хамт олныг оны эцэст шалгаруулж болно.

12.2. Ажилтан бүр аюулгүй ажиллагааны заавар, журмыг дагаж мөрдөх, ажлын байранд гарч болзошгүй аюул, гарсан аваар ослын талаар мэдээлэх болон тохирсон хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгсэл өмсөх, хэрэглэх, өөрийн болон хамт ажиллагсдынхаа эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах үүрэгтэй бөгөөд аюулгүй ажиллагааны бодлогыг хэрэгжүүлэхэд өөрийн хувь нэмрийг оруулж, санаачилга гаргасан ажилтнуудыг байгууллагын зүгээс урамшуулна.

Арван гурав. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн арга хэмжээний санхүүжилт

13.1. “Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудал нь үйлдвэрлэл, үйлчилгээний зардлынхаа 1.5 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулна.

13.2. Иргэн, ажилтан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаархи аливаа арга хэмжээний зардлыг хариуцахгүй.

13.3. Журмын 13.1-д заасан хөрөнгийг дараах арга хэмжээнд зарцуулна.

- а. хөдөлмөрийн нөхцөлийг мэргэжлийн байгууллагаар тодорхойлуулах
- б. хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт сурталчилгаа
- в. ажилтныг эрүүл мэндийн урьдчилсан ба хугацаат үзлэгт хамруулах
- г. ажилтныг сувилах, хөдөлмөрийн чадвар алдалтыг нөхөн сэргээх
- д. ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл
- е. ажлын байр, үйлдвэрлэлийн орчны аюул, эрсдэлгүй байдлыг хангах
- ё. хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн бүтэц, ажилтан, дэд зөвлөлийн чиг үүрэгт хамаарах үйл ажиллагаа
- з. ажилтныг амь нас, эрүүл мэндийн даатгалд хамруулах
- и. хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх бусад арга хэмжээ

ХООСОН ҮЛДЭЭВ

Нэмэлт, өөрчлөлтийн талаарх мэдээлэл

Д/д	Бүлэг заалтын дугаар	Нэмэлт <u>/+/</u> буюу Хасалт <u>/-</u>	Нэмэлт, өөрчлөлтийн бичвэр
1.			
2.			
3.			
4.			
5.			